

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГААНЫ АЛБА

**ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН УЛС ТӨРИЙН НАМЫН
ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ БА НАМЫН САНХҮҮЖИЛТ**

(Харьцуулсан судалгаа)
СТ-18/206

Захиалагч: Төрийн байгуулалтын байнгын
хорооны дарга, УИХ-ын Ажлын
хэсгийн ахлагч Д.Лүндээжанцан

Хянасан: Ц.Норовдондог (Ph.D)

Судлаачид: Ц.Болормаа
Г.Билгээ

Улаанбаатар хот
2018

АГУУЛГА

Нэг. Улс төрийн намын талаарх Үндсэн хуулийн зохицуулалт	2
1.1. Улс төрийн нам байгуулах тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт	4
1.2. Улс төрийн намд тавих хязгаарлалтын тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт	8
1.3. Улс төрийн намын хариуцлагын тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт	11
1.4. Улс төрийн намд хориглосон үйл ажиллагааны тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт	15
Хоёр. Улс төрийн намын санхүүжилт	18
2.1. Төрөөс санхүүжих	22
2.2. Хувийн хандивлагчдаас санхүүжих	22
2.3. Төр болон хувийн хосолсон хувилбараар санхүүжих	23
2.4. Хувиараа хандивлагчдад зарцуулалтын талаар нээлттэй тайлагнах	24
2.5. Зарцуулах журам	25
2.6. Зарцуулалтын нээлттэй тайлан	25
2.7. Хууль сахиулах, албан шаардлага	26
2.8. Хэвлэл мэдээллийн хэрэгсэллээр мэдээлэл түгээх	26

НЭГ. УЛС ТӨРИЙН НАМЫН ТАЛААРХ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ Техасын Их Сургууль, Чикагогийн Их Сургууль, Лондонгийн Их Сургууль, АНУ-ын Энх тайвны институтаас хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бий болгосон олон улсын Үндсэн хуулийн нэгдсэн сан буюу www.constituteproject.org цахим хуудас дахь эх сурвалжийг ашиглав.

Тус цахим хуудаст байршуулсан 192 орны Үндсэн хуульд улс төрийн намын талаар зохицуулсан эсэх, хэрэв зохицуулсан бол хэрхэн зохицуулсныг түүвэрлэн үзэхэд:

1. улс төрийн нам байгуулах тухай зохицуулсан - 121 улс;
2. улс төрийн намд тавих хязгаарлалтын тухай зохицуулсан - 94 улс;
3. улс төрийн намын хариуцлагын тухай зохицуулсан - 38 улс;
4. улс төрийн намд хориглох үйл ажиллагааны тухай зохицуулсан - 57 улс байна.

192 улсаас 86 улсын¹ Үндсэн хуульд хүнийг “улс төр”-ийн үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байхыг тодорхой заасан байна. Мөн дээрх улс орнуудаас 5 нь “нам төвтэй” улс байх бөгөөд эдгээр нь Хятад, Конго, Куба, БНАСАУ, Вьетнам зэрэг улс орнууд байна.

Хамрагдах улс орнуудыг дээр дурдсан 4 ангиллаар дараахь хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Үндсэн хуульд улс төрийн намын талаарх зохицуулалт

№	Үндсэн хуулийн зохицуулалтын агуулга, улсын тоо	Улсын нэр
1.	Улс төрийн нам байгуулах тухай зохицуулсан - 121 улс	Азербайжан, Албани, Алжир, Ангол, Андорра, Аргентин, Армен, Афганистан, Багамын арлууд, Барбадос, Белиз, Бенин, Болгар, Боливи, Бразил, Буркина Фасо, Бурунди, Бутан, Вануату, Венесуэль, Габон, Гаити, Гамби, Гана, Гватемал, Гвиана, Гвиней, Гвиней-Бисау, Герман, Гондурас, Грек, Гүрж, Доминикан, Египет, Жибути, Замби, Зимбабве, Зүүн Тимор, Ирак, Иран, Испани, Итали, Йемен, Йордан, Кабо Верде, Камбож, Кени, Киргиз, Колумби, Коморос, Конго (Бүгд Найрамдах Ардчилсан), Коста-Рика, Кот д'Ивуар, Латви, Либер, Ливи, Литва, Мавритани, Мадагасгар, Македон, Малави, Мали, Мальдив, Марокко,

¹ Азербайжан, Албани, Антигуа Барбуда, Армен, Багамын арлууд, Барбадос, Белиз, Бенин, Болгар, Боливи, Босни-Герцеговин, Ботсвана, Буркина Фасо, Вьетнам, Гамби, Гвиана, Гвиней, Герман, Грек, Гренада, Гүрж, Доминика, Доминикан, Египет, Замби, Зимбабве, Их Британи (ИБУИНВУ), Кабо Верде, Камбож, Кипр, Кирибати, Колумби, Конго (Бүгд Найрамдах Ардчилсан), Косово, Лесото, Либер, Ливи, Маврикий, Мадагасгар, Македон, Малави, Мали, Мальдив, Мальта, Маршалын арлууд, Мозамбик, Молдав, **Монгол**, Науру, Нигер, Нигери, Нидерланд, Өмнөд Судан, Панам, Папуа Шинэ Гвиней, Парагвай, Португал, Руанда, Румын, Самоа, Сан-Томе Принсили, Сент-Висент ба Гренадин, Сент-Луис, Словак, Словени, Соломоны арлууд, Сомали, Судан, Таджикистан, Тайван, Тайланд, Того, Тувалу, Турк, Туркменистан, Украин, Унгар, Хорват, Чад, Чех, Швейцар, Шинэ Зеланд, Шри Ланк, Эквадор, Эстони, Ямайка.

		Мексик, Мозамбик, Молдав, Монгол , Монтенегро, Мьянмар, Намиби, Непал, Нигер, Нигери, Никарагуа, Норвег, Өмнөд Африк, Өмнөд Солонгос (БНСУ), Өмнөд Судан, Пакистан, Папуа Шинэ Гвиней, Парагвай, Перу, Польш, Португал, Руанда, Румын, Сальвадор, Сан-Томе Принсипи, Сейшелийн арлууд, Сент-Китс ба Невис, Сент-Луис, Серби, Сири, Словак, Соломоны арлууд, Сомали, Судан, Суринам, Сьерра-Леоне, Тажикистан, Тайланд, Танзани, Того, Тувалу, Тунис, Турк, Туркменистан, Уганда, Узбекистан, Украин, Унгар, Фижийн арлууд, Франц, Хорват, Чад, Чех, Эквадор, Экваторын Гвиней, Эстони, Этиоп
2.	Улс төрийн намд тавих хязгаарлалтын тухай зохицуулсан - 94 улс	Албани, Алжир, Ангол, Аргентин, Армен, Афганистан, Болгар, Боливи, Бразил, Бурунди, Бутан, Габон, Гаити, Гамби, Гана, Гвиана, Гвиней, Гвиней-Бисау, Герман, Гондурас, Гүрж, Доминикан, Египет, Жибути, Зимбабве, Ирак, Иран, Испани, Йемен, Йордан, Кабо Верде, Казахстан, Камерун, Кени, Кипр, Киргиз, Колумби, Коморос, Конго (Бүгд Найрамдах Ардчилсан), Коста-Рика, Кот д'Ивуар, Либер, Ливи, Литва, Маврикий, Мавритани, Македон, Марокко, Мексик, Мозамбик, Монгол , Монтенегро, Мьянмар, Непал, Нигери, Никарагуа, Өмнөд Солонгос (БНСУ), Өмнөд Судан, Папуа Шинэ Гвиней, Парагвай, Перу, Португал, Руанда, Румын, Сальвадор, Сан-Томе Принсипи, Сейшелийн арлууд, Сенегал, Серби, Сири, Словак, Сомали, Судан, Сьерра-Леоне, Тажикистан, Тайланд, Танзани, Того, Тунис, Турк, Туркменистан, Уганда, Узбекистан, Украин, Унгар, Фижийн арлууд, Филиппин, Франц, Хорват, Чех, Чили, Эквадор, Экваторын Гвиней, Этиоп
3.	Улс төрийн намын хариуцлагын тухай зохицуулсан - 38 улс	Албани, Армен, Болгар, Буркина Фасо, Бутан, Гамби, Гвиана, Герман, Гүрж, Египет, Жибути, Кабо Верде, Колумби, Либер, Македон, Марокко, Мексик, Молдав, Монтенегро, Мьянмар, Никарагуа, Өмнөд Солонгос (БНСУ), Пакистан, Польш, Руанда, Румын, Словак, Словени, Сьерра-Леоне, Тайван, Танзани, Турк, Узбекистан, Филиппин, Хорват, Чили, Шри Ланк, Эстони
4.	Улс төрийн намд хориглосон үйл ажиллагааг зохицуулсан - 57 улс	Албани, Алжир, Ангол, Армен, Афганистан, Беларусь, Белиз, Болгар, Буркина Фасо, Бутан, Габон, Гамби, Гвиней-Бисау, Герман, Гүрж, Египет, Жибути, Ирак, Итали, Кабо Верде, Кени, Киргиз, Кот д'Ивуар, Либер, Ливи, Мавритани, Мадагаскар, Македон, Марокко, Мексик, Молдав, Монтенегро, Мьянмар, Непал, Нигер, Өмнөд Солонгос (БНСУ), Пакистан, Панам, Польш, Руанда, Румын, Сенегал, Серби, Сири, Сьерра-Леоне, Тажикистан, Тайван, Танзани, Туркменистан, Узбекистан, Украин, Филиппин, Хорват, Чили, Шри Ланк, Экваторын Гвиней, Эстони

1.1.Улс төрийн нам байгуулах тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт

Улс төрийн нам байгуулах тухай асуудлыг Үндсэн хуульдаа тусгасан 121 улс байна. Эдгээр улсуудын улс төрийн нам байгуулах тухай Үндсэн хуулийн зохицуулалтыг нэгтгэн үзвэл, иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж улс төрийн нам (эсхүл улс төрийн байгууллага)-ыг чөлөөтэй байгуулах эрхтэй байна. Ингэхдээ улс орнуудын Үндсэн хуульд дараахь онцлог зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

- төрөөс намын үйл ажиллагааны эрх чөлөөг хангах;
- намын зорилго нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байх;
- нам нь төрийн эрх мэдлийг шууд хэрэгжүүлэхгүй, төрийн эрх мэдлийг хяналтандаа байлгахыг хориглоно;
- намын үйл ажиллагаа нь үндэсний эрх ашигт нийцсэн байх;
- нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг төлөвшүүлэх, илэрхийлэхэд оролцох;
- нам нь үндэсний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хууль дээдлэх ёс болон ардчилалын зарчмуудад тулгуурлах;
- намын хөрөнгө, санхүүжилт, тэдгээрийн эх үүсвэр, олон нийтээс авах хандивын хэмжээг нийтэд мэдээллэх үүрэгтэй байх;
- нам нь улс төрийн олон ургалч үзлийг илэрхийлэх;
- хэнийг ч албан хүчээр намын гишүүн болгохгүй байх;
- намын нэр нь аливаа шашин шүтлэг, сүм хийдийн бэлгэдлийг агуулахгүй байх гэх мэт онцлог шинжийг агуулж байна.

Хүснэгт 2. Улс төрийн нам байгуулах тухай зохицуулалт

албан бус орчуулга

№	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1.	Армен	<p>8.2.Улс төрийн нам байгуулах, үйл ажиллагаа явуулах нь чөлөөтэй. Намуудад үйл ажиллагаа явуулах хууль зүйн тэгш боломжийг хуулиар баталгаажуулна.</p> <p>8.3.Улс төрийн нам нь ард түмний улс төрийн хүсэл зорилгыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>8.4.Улс төрийн намын бүтэц, үйл ажиллагаа нь ардчиллын зарчимд нийцсэн байна.</p> <p>46.1.Иргэн бүр бусад иргэнтэй хамтран нам байгуулах, намын гишүүн болох эрхтэй. Хэнийг ч албан хүчээр намын гишүүн болгох ёсгүй.</p>
2.	Болгар	<p>11.3. Бүх улс төрийн нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг төлөвшүүлэх, улс төрийн хүсэл зоригоо илэрхийлэхэд нь хөндлөнгөөс оролцоно.</p> <p>Улс төрийн намыг үүсгэн байгуулах, татан буулгах үндэслэл, нөхцөл, журам болон үйл ажиллагааны үндсийг хуулиар тогтооно.</p>

3.	Герман	<p>21.1.Улс төрийн нам нь ард түмний улс төрийн хүсэл зориг бүрэлдэхэд дэмжиж оролцоно.</p> <p>Иргэд улс төрийн намыг чөлөөтэй байгуулж болно.</p> <p>Намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан зарчмуудад нийцсэн байна.</p> <p>Нам нь өөрийн хөрөнгө, түүний эх үүсвэр, санхүүжилт болон зарлагыг нийтэд тайлагнах үүрэгтэй.</p>
4.	Хорват	<p>6.Улс төрийн нам үүсгэн байгуулах эрх чөлөөтэй.</p> <p>Улс төрийн намын дотоод зохион байгуулалт үндсэн хуулийн суурь зарчим болон ардчиллын зарчимд нийцсэн байна.</p> <p>Улс төрийн намууд өөрийн хөрөнгөтэй байх бөгөөд эд хөрөнгийн эх сурвалжаа нийтэд мэдээлэх үүрэгтэй...</p> <p>Улс төрийн намын эрх зүйн байдал болон санхүүжилтийг хуулиар зохицуулна.</p>
5.	Эстони	<p>48.Хэн ч ашгийн бус аливаа холбоо үүсгэн байгуулах эрхтэй. Зөвхөн Эстони Улсын иргэд улс төрийн намд харьяалагдана...</p> <p>Аливаа байгууллагууд, холбоод болон улс төрийн намын зорилго, эсхүл үйл ажиллагаа нь Эстонийн Үндсэн хуулийн дэглэмийг хүчээр өөрчлөхөд чиглэсэн, эсхүл эрүүгийн хариуцлага хүлээхүйц бусад зөрчил гаргахыг хориглоно.</p> <p>Шүүх хууль зөрчсөн гэж үзсэн улс төрийн нам, эсхүл намуудын эвсэл болон адилтгах байгууллагыг торгох, үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх болон тухайн улс төрийн намыг татан буулгана.</p>
6.	Унгар	<p>8.3.Улс төрийн нам нь эвлэлдэн нэгдэх эрхийн үндсэн дээр байгуулагдаж, үйл ажиллагаа явуулна.</p> <p>Улс төрийн нам ард түмний улс төрийн үзэл бодлыг төлөвшүүлэх, илэрхийлэхэд оролцоно.</p> <p>Улс төрийн нам нь төрийн эрх мэдлийг шууд хэрэгжүүлэхгүй.</p>
7.	Норвеги	<p>101.Хүн бүр аливаа хөдөлмөрийн байгууллага болон улс төрийн нам байгуулах, элсэх болон намаас гарах эрхтэй.</p> <p>...²</p>
8.	Словак	<p>2.Иргэд улс төрийн нам, улс төрийн хөдөлгөөн болон холбоог үүсгэн байгуулж болно.</p>
9.	Серб	<p>5.Улс төрийн намын үүрэг нь ардчилсан ёсны хүрээнд иргэдийн улс төрийн хүсэл зоригийг төлөвшүүлэх, хүлээн зөвшөөрөхөд оршино.</p> <p>Улс төрийн намыг байгуулах нь чөлөөтэй.</p>

² Улс төрийн намын тухай бусад заалтыг судалгааны холбогдох хэсэгт оруулсан.

10.	Турк	68.Иргэд улс төрийн нам үүсгэн байгуулах, намд элсэх болон намаас гарах эрхтэй. Арван найм ба түүнээс дээш насанд хүрсэн иргэн намын гишүүн болж болно.
11.	Румын	8.2.Улс төрийн намыг үүсгэн байгуулах болон үйл ажиллагааны нөхцөл, журмыг хуулиар тогтооно. Улс төрийн нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг төлөвшүүлэх болон илэрхийлэхдээ үндэсний тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, хууль дээдлэх болон ардчиллын зарчмуудыг хүндэтгэнэ.
12.	БНСУ	8.1.Улс төрийн намыг чөлөөтэй үүсгэн байгуулах бөгөөд олон намын тогтолцоотой байна.
13.	Испани	6.Улс төрийн нам нь ард түмний олон ургалч үзэл, иргэдийн улс төрийн хүсэл зоригийг төлөвшүүлэх болон илэрхийлэх улс төрийн оролцооны чухал хэрэгсэл мөн. Улс төрийн намыг үүсгэн байгуулах болон намын үйл ажиллагаа нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байна. Намын дотоод бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ардчилсан байна.
14.	Итали	49.Итали Улсын иргэн хэн ч ардчилсан үйл явцаар дамжуулан үндэсний бодлого тодорхойлоход хувь нэмрээ оруулахын тулд улс төрийн намыг чөлөөтэй байгуулах эрхтэй.
15.	Камбож	42.Кхмер иргэд нь аливаа холбоо болон улс төрийн нам байгуулах эрхтэй. Энэ эрхийг хуулиар тогтооно. Кхмер иргэд үндэсний ололт, нийгмийн дэг журмыг хамгаалахын төлөө олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд хамтран оролцож болно.
16.	Молдав	41.1.Иргэн бүр нам, нийгэм-улс төрийн бусад байгууллагад чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, нийгэм-улс төрийн бусад байгууллага нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг тодорхойлох, илэрхийлэх болон хууль дээдлэх ёсны дагуу сонгуулийн үйл явцад оролцоход нь хамтран ажиллана.
17.	Польш	11.1.Бүгд Найрамдах Польш Улс нь улс төрийн нам байгуулах болон тэдгээрийн үйл ажиллагааны эрх чөлөөг хангана. Улс төрийн намыг Польш иргэдийн сайн дурын үндсэн дээр тэгш эрхийн зарчимд үндэслэн байгуулна. Улс төрийн намын зорилго нь төрийн бодлогыг тодорхойлоход ардчилсан арга замаар нөлөөлөхөд оршино.
18.	Португал	51 дүгээр зүйл. Улс төрийн холбоо болон нам 51.1.Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө нь улс төрийн холбоод, нам байгуулах, эсхүл намууд нэгдэх эрхийг агуулахаас гадна тэдгээрээр дамжуулан хамтын хүчээр, ардчилсан ёсоор ард түмний хүсэл зоригийг бүтээж, улс төрийн эрх мэдлийг зохион байгуулахыг ойлгоно.

		<p>51.2.Хэн ч нэгээс дээш улс төрийн намын гишүүнээр нэгэн зэрэг бүртгүүлэхгүй, хэн ч хуулийн дагуу байгуулагдсан аль нэг намын гишүүн болсон, эсхүл намын гишүүнчлэлээ больсныхоо төлөө аливаа эрхийг нь хасахыг хориглоно.</p> <p>51.3.Намын тунхагласан үзэл баримтлал эсхүл үндсэн зарчмаар нь ялгаварлалгүйгээр улс төрийн намуудыг ямар нэгэн шашин болон сүм хийдтэй шууд холбогдох нэр авах, мөн төрийн болон шашны сүлд тэмдэгтэй ижил төсөөтэй сүлд тэмдэг хэрэглэхийг хориглоно.</p> <p>51.4.Нам нь аль нэг бүс нутгийн үндсэн шинж, хүрээг хамарсан нэр, үзэл баримтлалтай байх ёсгүй.</p> <p>51.5.Улс төрийн нам нь үйл ажиллагаандаа ил тод байдал, ардчилсан удирдлага, зохион байгуулалт болон бүх гишүүдийн оролцоог хангах зарчмыг удирдлага болгоно.</p> <p>51.6.Улс төрийн намын санхүүжилт, түүнд тавигдах шаардлагууд, олон нийтээс авах хандивын хэмжээ хязгаар, хөрөнгө болон дансны мэдээллийг нийтэд мэдээлэхийг хуулиар зохицуулна.</p>
19.	Румын	<p>8.2.Улс төрийн нам байгуулах болон улс төрийн намын аливаа үйл ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдана.</p> <p>Улс төрийн нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг тодорхойлох, илэрхийлэх, үндэсний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хууль дээдлэх ёс, ардчиллын зарчмуудыг хүндэтгэхэд хувь нэмэр оруулна.</p>
20.	Суринам	<p>53.1.Төр нь иргэдийн хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд улс төрийн нам байгуулах эрх чөлөөг хүлээн зөвшөөрнө.</p> <p>53.2.Улс төрийн нам нь үндэсний тусгаар тогтнол, ардчиллыг хүндэтгэх шаардлагатай.</p> <p>53.3.Улс төрийн нам эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь зүйлсийг харгалзан үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> а) улс төрийн намын зорилго нь Үндсэн хууль болон бусад хуулийг зөрчихгүй байх; б) нам нь хуулиар тогтоосон шалгуурыг хангасан Суринам иргэнд нээлттэй байх ба Суринам иргэн нь намын үндсэн зарчмыг хүлээн зөвшөөрсөн байх; в) намын дотоод зохион байгуулалт нь ардчилсан байх; г) сонгогчдод улс төрийн намын улс төрийн болон сонгуулийн хөтөлбөрийн талаар мэдээлсэн байх; д) нам нь жил бүр орлогын эх үүсвэр болон тайлангаа Бүгд Найрамдах Суринам Улсын албаны ёсны сонин (Official Journal of the Republic of Suriname) болон бусад сонинд нийтлэх; е) улс төрийн нам үйл ажиллагааныхаа нээлттэй, ил тод байдлыг хангаж, сайн засаглалын зарчмууд болон хуулиар тогтоосон журмын дагуу явуулах; ё) үндэсний ашиг сонирхлыг хөхиүлэн дэмжихийн тулд нэгдсэн зорилготой хөтөлбөр боловсруулах.

1.2. Улс төрийн намд тавих хязгаарлалтын тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт

Улс төрийн намд тавих хязгаарлалтыг дэлхийн 94 улсын Үндсэн хуульд тусгасан байна.

Улс орны Үндсэн хуулийг судлан үзэхэд дараахь “**нийтлэг хязгаарлалт**”-ыг Үндсэн хуулиар тогтоосон байна:

- Нам нь үндэсний эв нэгдэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдлыг алдагдуулахгүй байх;
- төрийн эрх мэдлийг шууд хэрэгжүүлэхгүй байх, төрийн эрх мэдлийг өөрийн хяналтад байлгахгүй байх;
- намын зорилго, үйл ажиллагаа нь ардчилалын суурь зарчмуудыг зөрчихгүй байх;
- намын үйл ажиллагаа нь Үндсэн хууль, бусад хуульд нийцсэн байх;
- иргэдийн улс төрийн хүсэл зорилгыг бүрдүүлэх, илэрхийлэхэд оролцох зэрэг нийтлэг хязгаарлалтыг Үндсэн хуульд тусгасан байна.

Мөн дараахь “**онцлог хязгаарлалт**” ч байна. Үүнд:

- нам нь үндэсний ашиг сонирхлыг нэн тэргүүнд авч үзэх;
- нам нь сонгуулийн ашгийн төлөө сонгогчдын үндэс угсаа, бүс нутаг, шашин шүтлэгийг ашиглахгүй байх;
- намын нэр, үзэл баримтлал нь аль нэг бүс нутгийг хамарсан шинжгүй байх;
- намын нэр, үзэл баримтлал аль нэг шашны бэлгэдэл, номлолыг илэрхийлэхгүй байх;
- нам арилжааны үйл ажиллагаа эрхлэхгүй³;
- улс төрийн намын зорилго, үйл ажиллагаа нийцэж байх ёстой;
- нам нь хүйсийн тэгш эрх, харилцан ойлголцлыг хангах;
- нам хөтөлбөр, үйл ажиллагаагаараа үндэсний энх тайвныг хангах ёстой;
- хилийн гадна байгуулсан улс төрийн байгууллага, үйл ажиллагааг хориглоно зэрэг хязгаарлалтууд тавигдсан байна.

Хүснэгт 3. Улс төрийн намд тавих хязгаарлалтын тухай зохицуулалт

№	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1.	Серб	5. Улс төрийн нам нь төрийн эрх мэдлийг шууд хэрэгжүүлэхгүй, эсхүл төрийн эрх мэдлийг өөрийн хяналтад авахгүй.
2.	Франц	4. Улс төрийн нам болон бүлгүүд нь иргэдийн сонгох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Улс төрийн нам болон бүлгийг чөлөөтэй байгуулж, үйл ажиллагаа явуулна. Улс төрийн нам болон бүлгүүд нь үндэсний бүрэн эрхт байдал, ардчиллын зарчмуудыг баримтална.

³ Турк Улсын зохицуулалтыг Хүснэгт 4-т бүхлээр нь оруулсан тул тэндээс үзнэ үү.

		Улс төрийн нам болон бүлэг нь Үндсэн хуулийн энэ зүйлийн 2 дахь догол мөрт ⁴ заасан зарчмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үндсэн хууль нь улс төрийн нам, бүлгүүдийн ардчилал, олон ургалч үзэл, эрх тэгш оролцооны илэрхийллийн баталгаа болно.
3.	Бутан	15.1.Улс төрийн нам нь бусад бүх эрх ашгаас үндэсний эрх ашгийг нэн тэргүүнд тавих бөгөөд энэ зорилгоо хангахын тулд хариуцлагатай, сайн засаглалын төлөө иргэдийн хүсэл зориг, үнэт зүйлд үндэслэсэн сонгууль явуулна. 15.3.Нэр дэвшигчид болон улс төрийн намууд сонгуулийн ашгийн төлөө сонгогчдыг үндэс угсаа, бүс нутаг, шашин шүтлэгийг ашиглах ёсгүй.
4.	Йордан	16.2.Йорданчууд нийгэмлэг, холбоо, улс төрийн нам байгуулах эрхтэй бөгөөд тэдгээрийн зорилго нь хуульд нийцсэн, арга барил нь энх тайвныг эрхэмлэсэн, дүрэм нь Үндсэн хууль зөрчөөгүй байна.
5.	Кени	91.1.Бүх улс төрийн нам нь: а) хуулиар тогтоосон үндэсний хэмжээнд зохион байгуулагдах; б) ардчилсан сонгуульд удирдах байгууллагатай байх; в) үндэсний эв нэгдлийг хөхиүлэн дэмжих; г) сайн засаглалын ардчилсан зарчмуудыг дагаж мөрдөн, нам доторхи шударга, чөлөөт сонгуулийг дэмжиж тогтмол явуулах; е) хүн бүрийн, ялангуяа цөөнх, эмзэг бүлгийнхний улс төрийн оролцооны эрхийг хангах; ё) хүний эрх, үндсэн эрх чөлөө, хүйсийн эрх тэгш байдлыг хүндэтгэн дэмжих; ж) Үндсэн хуулийн зорилго, зарчим болон хууль дээдлэх ёсыг хангах; з) улс төрийн намын ёс зүйн дүрмийг батлан дагаж мөрдөх.
6.	Коста-Рика	98. ... Улс төрийн нам нь улс төрийн олон ургальч үзлийг илэрхийлж, иргэдийн хүсэл зоригийг тодорхойлоход оролцох болон улс төрийн оролцоог хангах үндсэн арга хэрэгсэл болно. Улс төрийн намыг чөлөөтэй байгуулах ба намын үйл ажиллагаа нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байна. Улс төрийн намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа ардчилсан байна.
7.	Мозамбек	74.1.Нам нь улс төрийн олон ургальч үзлийн илэрхийлэл байна. Нам нь ард түмний хүсэл зоригийг төлөвшүүлж, илэрхийлэхэд оролцох бөгөөд энэ нь төрийн удирдлагад ард түмний ардчилсан оролцоог хангах үндсэн хэрэгсэл болно.

⁴ Франц Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйл:

...Үндсэн хууль нь сонгуульд болон бусад албан тушаалд, мөн мэргэжлийн болон нийгмийн хариуцлагатай албан тушаалд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш боломжийг дэмжинэ.

		<p>74.2.Улс төрийн намын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа ардчилсан байна.</p> <p>75.1.Улс төрийн нам нь үндэсний эв нэгдэл, ардчилсан үнэт зүйлсийг чин сэтгэлээсээ хүндлэх үүднээс Үндсэн хууль болон бусад хуульд бататгасан зарчмуудыг баримтална.</p> <p>75.2.Улс төрийн нам нь өөрсдийн зорилгыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ дор дурдсан зарчмыг баримтална:</p> <ul style="list-style-type: none"> а) нам үндэсний хэмжээний байх; б) үндэсний эрх ашгийг хамгаалах; в) олон нийтийн санаа бодол, ялангуяа үндэсний томоохон асуудлуудлыг тодорхойлох; г) иргэний эх оронч үзлийг бэхжүүлэх, Мозамбик үндэстэнг нэгтгэх. <p>75.3.Нам нь улс төрийн болон иргэний боловсролоор дамжуулан улс орны энх тайван, тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулна.</p> <p>75.4.Нам байгуулах болон зохион байгуулалт, үйл ажиллагааг хуулиар тогтооно.</p>
8.	Монтенегро	54.Гадаадын иргэдийн байгуулсан улс төрийн байгууллага болон үйл ажиллагаа, Монтенегро Улсын гадна байгуулсан улс төрийн байгууллага, түүний аливаа үйл ажиллагааг хориглоно.
9.	Мьянмар	<p>404.Улс төрийн нам:</p> <ul style="list-style-type: none"> а) зорилго нь Холбоог задруулахгүй, үндэсний эв нэгдлийг хангах, тусгаар тогтнолыг үүрд хадгалах; б) төрд үнэнч шударга байна. <p>405.Улс төрийн нам:</p> <ul style="list-style-type: none"> а) үнэнч шударга, дэг журамтай хөгжиж байгаа олон намын ардчилсан тогтолцоог хүлээн зөвшөөрч хэрэглэх; б) Үндсэн хууль болон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хуулийг хүндэтгэн сахих; с) хуульд нийцүүлэн улс төрийн намыг байгуулж, бүртгүүлэх үүрэгтэй.
10.	Руанда	<p>56.Улс төрийн нам нь өөрийн удирдах зөвлөлийн гишүүдийг томилохдоо руандачуудын нэгдмэл байдал, хүйсийн тэгш байдал, харилцан ойлголцлыг байнга хангана.</p> <p>Улс төрийн нам нь Үндсэн хууль болон бусад хуулийг дагаж мөрдөнө. Улс төрийн нам нь ардчилсан зарчимд нийцсэн байх бөгөөд үндэсний эв нэгдэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдлыг алдагдуулахыг хориглоно.</p>

1.3. Улс төрийн намын хариуцлагын тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт

Дэлхийн 38 орны Үндсэн хуулиар улс төрийн нам (байгууллага)-д хариуцлага тооцох үндэслэл, хариуцлагын төрөл болон түүнийг ногдуулах субъектийг заасан байна.

а) Хариуцлага тооцох үндэслэл:

- Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан аливаа үйл ажиллагааг дэмжсэн, явуулсан бол (*төрийн эрх мэдлийг шууд хэрэгжүүлэх, төрийн эрх мэдлийг хяналтандаа авах г.м*);
- гадаадын эх үүсвэрээс мөнгө, тусламж авсан бол;
- улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд заналхийлсэн бол;
- сонгуулийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн бол;
- ардчиллын үндсэн зарчимтай зөрчилдсөн үзэл санаа, уриа дэвшүүлсэн, үйл ажиллагаа явуулсан бол.

б) Хариуцлагын төрөл:

- торгох;
- улсын дэмжлэгээс хэсэгчлэн болон бүрэн хасах;
- түдгэлзүүлэх (үйл ажиллагааг түр зогсоох);
- сонгуульд оролцох эрхийг хасах;
- тараах (татан буулгах).

в) Хариуцлага ногдуулах субъект:

- Үндсэн хуулийн шүүх;
- Улсын дээд шүүх;
- шүүх.

Улс төрийн нам Үндсэн хууль зөрчсөн эсэхийг шалгуулах хүсэлт гаргах субъектын тухайд зарим улсад Засгийн газар, Гүржийн Үндсэн хуульд тусгайлан заасан олон субъект байх бол ихэнх улсын Үндсэн хуульд тус субъектийг тусгайлан заагаагүй байна.

Улс төрийн намд хариуцлага тооцох үндэслэл, хариуцлагын төрөл, түүнээс үүсэн гарах хууль зүйн үр дагаварыг тодорхой зохицуулсан улс бол Турк Улс байх тул зохицуулалтыг нь доорх хүснэгтээс нарийвчлан үзнэ үү.

Хүснэгт 4. Улс төрийн намын хариуцлагын тухай зохицуулалт

№	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1.	Хорват	6. Улс төрийн нам өөрийн хөтөлбөр, эсхүл хүч хэрэглэсэн үйл ажиллагаагаар чөлөөт ардчилсан ёсыг унагаж, Хорватын Бүгд Найрамдах улсын оршин тогтнолд аюул учруулах зорилго агуулсан бол тухайн улс төрийн намыг Үндсэн хуулийн бус гэж үзнэ.

		Улс төрийн намыг үндсэн хуулийн бус эсэх асуудлыг Хорват Улсын Үндсэн хуулийн цэц шийдвэрлэнэ.
2.	Эстони	48.Аливаа байгууллага, нэгдэл, улс төрийн нам хууль зөрчсөн эсэхийг зөвхөн шүүх тогтоох бөгөөд хууль зөрчсөн нь тогтоогдсон улс төрийн намын үйл ажиллагааг зогсоох, татан буулгах, торгох эсэхийг шүүх шийднэ.
3.	Турк	<p>68.Улс төрийн намын үйл ажиллагаа, дотоод журам нь ардчилсан зарчимд нийцсэн байна.</p> <p>Эдгээр зарчмын хэрэгжилтийг хуулиар зохицуулна.</p> <p>Улс төрийн нам нь арилжааны үйл ажиллагаа явуулахгүй.</p> <p>Улс төрийн намын орлого, зарлага нь зорилготойгоо нийцэх ёстой. Энэ журмын хэрэгжилтийг хуулиар зохицуулна. Улс төрийн намын орлого, худалдан авалт, зарлагын аудитыг Үндсэн хуулийн цэцээс хуульд заасны дагуу, аудитын зарчим, арга барилаар хийх ба хууль зөрчсөн тохиолдолд зохих хуулийн дагуу хариуцлага тооцно.</p> <p>Үндсэн хуулийн цэц нь аудит хийхдээ мэргэшсэн шүүхээс мэргэжлийн туслалцаа авна. Аудитын дүнд Үндсэн хуулийн цэцээс гарсан шийдвэр эцсийнх байна.</p> <p>Прокуророос гаргасан улс төрийн намыг татан буулгах хүсэлтийг давж заалдах шатны шүүхээр хэлэлцсэнийг Үндсэн хуулийн цэц эцэслэн шийдвэрлэнэ.</p> <p>Улс төрийн намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр нь Хуулийн 68-р зүйлийн 4-р хэсгийн заалтыг зөрчсөн нь тогтоогдвол тухайн намыг бүрмөсөн татан буулгана.</p> <p>Улс төрийн намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр нь Хуулийн 68-р зүйлийн 4-р хэсгийн заалтыг зөрчсөн шалтгаанаар намыг бүрмөсөн татан буулгах нь Үндсэн хуулийн цэц тухайн намыг хууль зөрчсөн үйлдлүүдийн гол цөм болохыг тогтоосон тохиолдолд хэрэгжинэ.</p> <p>Улс төрийн намын гишүүд дээрх үйлдлүүдийг идэвхтэйгээр хэрэгжүүлсэн, нөхцөл байдлыг ил далдаар Их хурал, Тэргүүлэгч болон шийдвэр гаргах дээд түвшний хүрээнд, мөн намын гүйцэтгэх аппаратын байгууллагууд, хэсгийн хурлуудаар, Туркийн Үндэсний Ассамблейн гүйцэтгэх зөвлөлийн түвшинд үйлдсэн, эсвэл намын бүтэц нь тэр аяараа хамарсан тохиолдолд тухайн намыг дээрх үйлдлийн гол цөм болсон гэж үзнэ.</p> <p>Үндсэн хуулийн цэцээс тухайн намыг бүр мөсөн татан буулгахын оронд шүүхээр тогтоосон гэм буруугийн хэмжээнээс нь хамааран төрөөс дэмжлэг тусламж авах байдлыг нь хэсэгчлэн болон бүрмөсөн хорьж болно.</p> <p>Бүр мөсөн татан буугдсан намыг өөр нэрээр дахин байгуулах боломжгүй.</p> <p>Хэлсэн үг, хийсэн үйлдлээс нь болж бүрмөсөн татан буугдсан намын үүсгэн байгуулагчид, гишүүд тухайн намыг татан буулгах тухай Үндсэн Хуулийн Цэцийн шийдвэр хэвлэгдэн албан ёсоор нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 5 жилийн дотор өөр ямар нэгэн</p>

		<p>намын үүсгэн байгуулагч, гишүүн, удирдах албан тушаалд байж болохгүй.</p> <p>Гадаад улсын төр, олон улсын байгууллага, бизнесийн байгууллага, хувь хүнээс тусламж авсан улс төрийн намыг бүрмөсөн татан буулгана.</p> <p>Улс төрийн намын үүсэл, үйл ажиллагаа, тэдгээрийн удирдлага, задрах явц, төрийн дэмжлэгээс бүтнээр болон хэсэгчлэн хасагдах, сонгуулийн зардал, улс төрийн намаас нэр дэвших зэрэг асуудлыг дээрх зарчимд суурилсан холбогдох хуулиар зохицуулна.</p>
4.	БНСУ	8.4.Хэрэв улс төрийн намын зорилго, үйл ажиллагаа нь ардчилалын үндсэн зарчимтай зөрчилдөж байна гэж үзвэл Засгийн газар энэ талаар Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах ба Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн дагуу улс төрийн нам тарна.
5.	ХБНГУ	<p>21.2. Өөрийн зорилго, эсхүл үзэл баримтлалынхаа хүрээнд ардчилсан чөлөөт үндсэн зарчмыг нураах, устгах, эсхүл Холбооны Бүгд Найрамдах Герман улсын оршин тогтнолд аюул учруулахуйц намыг Үндсэн хуулийн бус гэж үзнэ.</p> <p>Холбооны Үндсэн хуулийн цэц нь улс төрийн намыг Үндсэн хуулийн бус эсэхийг шийдвэрлэнэ.</p>
6.	Словени	160.Үндсэн хуулийн цэц нь улс төрийн намуудын үйл ажиллагаа, дүрмийг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэнэ.
7.	Албани	<p>131.1.Үндсэн хуулийн шүүх дор дурдсан асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ:</p> <p>д) намууд болон бусад улс төрийн байгууллагууд Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, тэдгээрийн үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлд⁵ нийцэж байгаа эсэхийг;</p>
8.	Бутан	<p>15.11.Зөвхөн Улсын дээд шүүхийн шийдвэрээр улс төрийн намыг татан буулгана:</p> <p>а) хэрэв улс төрийн намын зорилго, үйл ажиллагаа нь Үндсэн хуульд харшилсан бол;</p> <p>б) хэрэв гадаадын эх үүсвэрээс мөнгөн хөрөнгө, тусламж авсан бол;</p> <p>с) парламент, эсхүл хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн бусад үндэслэлээр;</p> <p>d) сонгуулийн тухай хуулийг зөрчсөн бол.</p>

⁵ Албанийн Үндсэн хуулийн 9 дүгээр зүйл:

1.Улс төрийн намыг чөлөөтэй байгуулна. Байгууллага нь ардчилсан зарчимд нийцсэн байх ёстой.
2.Улс төрийн намууд болон бусад байгууллагуудын тоталитар дэглэмд үндэслэх, арьс өнгө, шашин шүтлэг, бүс нутаг, эсхүл үндэсний үзэн ядалтыг өдөөх, дэмжих, төрийн эрхийг авах, эсхүл төрийн бодлогод нөлөөлөхийн тулд хүчирхийллийг ашиглах, мөн нууц шинж чанартай хөтөлбөр, үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглоно.
3.Улс төрийн намууд нь санхүүгийн эх үүсвэр, түүний зардлыг олон нийтэд байнга нээлттэй байлгана.

9.	Гүрж	<p>26.6.Олон нийтийн, эсхүл улс төрийн холбоодын үйл ажиллагааг зөвхөн шүүхийн шийдвэр болон органик хуулиар тогтоосон журмын дагуу түр зогсоож, эсхүл хориглож болно.</p> <p>89.1.Гүрж Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Парламентын 1/5-ээс доошгүй гишүүд, шүүх, Абхази, Ажараагийн автономит бүгд найрамдах улсын төлөөллийн дээд байгууллагууд, Сакребулосийн нутгийн өөрөө удирдах ёсны төлөөллийн байгууллагууд, Шүүхийн дээд зөвлөл, Ардын хамгаалагч, эсхүл иргэний гаргасан гомдолд үндэслэн органик хуулиар тогтоосон журмын дагуу Гүрж Улсын Үндсэн хуулийн шүүх дор дурдсан асуудлуудыг шийдвэрлэнэ:</p> <p>с) иргэдийн улс төрийн холбоодын зохион байгуулалт, үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг;</p>
10.	Пакистан	<p>17.2.Пакистан Улсад (төрийн) алба хаагаагүй иргэн бүр Пакистан Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг тогтоосон хууль тогтоомжид заасан хязгаарт улс төрийн нам байгуулах, эсхүл намын гишүүн байх эрхтэй.</p> <p>Хуулийн дагуу Холбооны Засгийн газар нь Пакистан Улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдалд хохирол учруулж байгаа улс төрийн нам байгуулагдсан, эсхүл үйл ажиллагаа явуулж байгаа талаар мэдэгдэнэ.</p> <p>Холбооны Засгийн газар мэдэгдэл хийснээс хойш 15 хоногийн дотор Дээд шүүхэд энэ асуудлыг шилжүүлэх ба Дээд шүүхийн гаргасан шийдвэр эцсийнх байна.</p>
11.	Польш	<p>188.Үндсэн хуулийн шүүх дор дурдсан асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ:</p> <p>4)улс төрийн намуудын зорилго, үйл ажиллагаа нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар;</p>
12.	Тайвань	<p>5.Хэрэв улс төрийн намын зорилго, эсхүл үйл ажиллагаа нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын бүрэн эрхт байдал, эсхүл үндэсний Үндсэн хуулийн эрх чөлөөт, ардчилсан дэг журамд аюул учруулж байвал түүнийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзнэ.</p>

1.4. Улс төрийн намд хориглосон үйл ажиллагааны тухай зарим улсын Үндсэн хуулийн зохицуулалт

Улс төрийн намд хориглох үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг 57 улсын Үндсэн хуульд тусгасан байна. Үндсэн хуулиар дор дурдсан үйл ажиллагааг хориглосон байна. Үүнд:

- улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа явуулахыг;
- ардчилсан болон хууль дээдлэх ёсны зарчим, олон ургальч үзлийн эсрэг үзэл баримтлал, уриа дэвшүүлж, үүнд чиглэсэн үйл ажиллагаа явуулахыг;
- арьс өнгө, хүйс, шашин, хэл, газар зүйн байршил, үндэсний цөөнх дээр үндэслэж нам байгуулахыг;
- цэрэг, цэрэгжсэн, эсхүл нууц үйл ажиллагаа эрхэлсэн байгууллага байгуулахыг;
- гадаадаас мөнгөн хөрөнгө, хандив авахыг;
- улсын хөрөнгө авах, ашиглах, шамшигдуулахыг;
- хээл хахууль, авлигын шинжтэй үйлдэл хийх болон зохион байгуулахыг;
- төрийн болон орон нутгийн байгууллагууд нам байгуулах, намын үйл ажиллагаа явуулахыг хориглох;
- албан үүргээс гүйцэтгэхээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн төрийн байгууллага, хууль сахиулах байгууллагуудын албан хаагчид улс төрийн намын үйл ажиллагаа явуулахыг хориглох;
- гадаадын улс төрийн намууд (байгууллагууд)-тай хамаатай байхыг;
- нацизм, фашизм, коммунизмын загвар дээр үндэслэсэн үйл ажиллагаа явуулахыг тус тус хориглосон байна.

Хүснэгт 5. Улс төрийн намд хориглосон зохицуулалт

№	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1.	Ангол	<p>17.2. Улс төрийн намын дүрэм, үйл ажиллагаа нь хуульд нийцсэн байх ёстой бөгөөд дараахь үндсэн зарчмыг баримтална:</p> <p>а) улс төрийн намын үйл ажиллагаа нь үндэсний эрх ашигт нийцсэн байх;</p> <p>б) дүрмээ чөлөөтэй батлах;</p> <p>в) зорилгоо олон нийтэд түгээх;</p> <p>г) гишүүнээр элсүүлэх эрх чөлөөтэй байх, нэг гишүүнчлэлтэй байх эрхтэй;</p> <p>д) зөвхөн энх тайвнаар зорилгодоо хүрэх; (цэрэг, цэрэгжсэн байгууллага байгуулах, эсхүл ашиглахыг хориглох)</p> <p>е) зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ардчилсан байх;</p> <p>ё) улс төрийн намуудын гишүүнчлэлийн доод хязгаарыг хуулиар тогтоох;</p> <p>ж) гадаадын засгийн газар, төрийн байгууллагын мөнгөн болон эдийн засгийн хандив авахыг хориглох;</p>

		з) төрийн хөрөнгийг ашиглах данс нээхийг хориглоно.
2.	Афганистан	<p>35.Афганистаны ард түмэн хуульд заасан журмын дагуу улс төрийн нам байгуулах эрхтэй бөгөөд ингэхдээ:</p> <p>1)улс төрийн намын үзэл баримтлал болон дүрэм нь Үндсэн хуульд заасан Исламын шашин, зарчмууд, үнэт зүйлстэй зөрчилдөхгүй байх ёстой;</p> <p>2)улс төрийн намын зохион байгуулалт, санхүүжилтийн эх үүсвэр ил тод байх ёстой;</p> <p>3)цэргийн, эсхүл хагас цэргийн зорилго, зохион байгууллагатай байх ёсгүй;</p> <p>4)улс төрийн намууд нь гадаадын улс төрийн намууд болон бусад байгууллагуудтай хамаатай байх ёсгүй.</p> <p>Нам байгуулах, тэдний үйл ажиллагаа нь овог, ашиг сонирхлын явцуурал, хэл, шашны хуваагдлыг хориглоно. Хуулийн дагуу байгуулагдсан намууд, эсхүл эвслийг эрх зүйн үндэслэл, шүүхийн шийдвэргүйгээр тарааж үл болно.</p>
3.	Египет	<p>74.Иргэд хуулийн дагуу улс төрийн нам байгуулах эрхтэй.</p> <p>Гарал үүсэл, хүйс, шашин, бүлэг, газарзүйн байршилд үндэслэж улс төрийн нам байгуулах, эсхүл үйл ажиллагаа явуулж үл болно. Ардчилалд заналхийлсэн, нууцлагдмал, цэргийн, эсхүл цэргийн шинжтэй аливаа үйл ажиллагаа явуулж болохгүй.</p>
4.	Кени	<p>91.2.Улс төрийн намд дор дурдсан үйл ажиллагааг хориглоно:</p> <p>а)арьс өнгө, угсаа, хүйс, шашин, хэл, бүс нутагт үндэслэх, эсхүл үзэн ядалтыг өмгөөлөхийг эрэлхийлэх;</p> <p>б)өөрийн гишүүд, дэмжигчид, сөрөг хүчнийхэн, эсхүл бусад этгээдэд хүч хэрэглэх, айлгах, эсхүл дэмжих;</p> <p>в)цэрэгжсэн хэлбэр, цагдаа, эсхүл түүнтэй ижил төстэй байгууллага байгуулах, дэмжих;</p> <p>г)хээл хахууль, эсхүл бусад төрлийн авлигын шинжтэй үйлдэл хийх;</p> <p>д)энэ бүлэг, эсхүл парламентын шийдвэрт зааснаас бусад тохиолдолд өөрийн, эсхүл сонгуульд нэр дэвшигчийнхээ ашиг сонирхолын төлөө улсын хөрөнгийг авах, ашиглах.</p>
5.	Киргиз	<p>4.4.Бүгд Найрамдах Киргиз Улсад дараахь зүйлийг хориглоно:</p> <p>1)төр, орон нутаг болон намын байгууллагууд нэгдэхийг; төрийн болон орон нутгийн байгууллагуудад нам байгуулах, үйл ажиллагаа явуулахыг; албан үүрэг гүйцэтгэхээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн албан хаагчид намын үйл ажиллагаа явуулахыг;</p> <p>2)арми, хууль сахиулах байгууллагуудын албан хаагчид, шүүгчид улс төрийн намд үүрэг гүйцэтгэхийг, мөн улс төрийн аль нэг намыг дэмжсэн мэдэгдэл хийхийг;</p> <p>3)шашны, эсхүл үндэсний цөөнхөд суурилсан улс төрийн нам байгуулахыг, мөн шашны холбоод улс төрийн зорилгод хүрэхийг;</p>

		<p>4)цэрэг дайны хэлбэрээр иргэдийн нийгэмлэг байгуулахыг;</p> <p>5)улс төрийн нам, нийгмийн болон шашны байгууллага, тэдний төлөөлөгчийн газрууд, салбаруудын үйл ажиллагаа нь улс төрийн зорилго агуулахыг, үндсэн хуулийн байгууллыг хүчээр өөрчлөхийг, үндэсний аюулгүй байдлыг доройтуулахыг, арьс өнгө, нийгэм, үндэстэн, ястан, шашин хоорондын мөргөлдөөнд хүргэхийг хориглоно.</p>
6.	Либер	<p>80-р зүйл.</p> <p>а) улс төрийн намын зорилго болон гишүүд, дэмжигчдийн зан үйл нь Либер Улсын чөлөөт ардчилсан нийгэмд хор хохирол учруулах, эсхүл Бүгд Найрамдах Улсын тусгаар тогтнолд заналхийхийг оролдож буй нам, эсхүл байгууллагын бүртгэлийг хүчингүй болгоно.</p> <p>б) Аливаа этгээд, эсхүл бүлэг этгээдээр хүч хэрэглэн, эсхүл албадан улс төрийн аливаа зорилго, ашиг сонирхлыг хамгаалуулахаар сургасан, тоноггосон аливаа этгээд, эсхүл бүлэг этгээдийг зохион байгуулсан нам болон улс төрийн бусад байгууллагыг бүртгэхгүй. Хэрэв бүртгэсэн бол бүртгэлийг хүчингүй болгоно.</p>
7.	Молдав	<p>41.4.Өөрийн зорилго, эсхүл үйл ажиллагаагаараа улс төрийн олон ургальч үзэл, хууль дээдлэх ёсны зарчмууд, Бүгд Найрамдах Молдав Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа нам, бусад нийгэм-улс төрийн байгууллагыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзнэ.</p> <p>41.6.Гадаадын иргэдээс бүрдсэн намын үйл ажиллагааг хориглоно.</p>
8.	Непал	<p>269.5.Хэрэв улс төрийн намын нэр, зорилго, бэлгэ тэмдэг, далбаа нь шашин болон улс орны нийгмийн эв нэгдлийг эвдэх, эсхүл хуваах зорилгыг агуулж байвал тус улс төрийн намыг бүртгэхгүй.</p>
9.	Польш	<p>13.Улс төрийн нам болон бусад улс төрийн байгууллагуудын хөтөлбөр нь тоталитар аргад, үйл ажиллагаа нь нацизм, фашизм, коммунизмын загварт үндэслэхийг, мөн хөтөлбөр, эсхүл үйл ажиллагаа нь арьсны өнгө, үндэсний үзэн ядалтыг дэмжихийг, эрх мэдэл олж авах, эсхүл төрийн бодлогод нөлөөлөхийн тулд хүчирхийлэл хэрэглэхийг, өөрийн зохин байгуулалт, гишүүдийнхээ нууцыг хадгалахыг тус тус хориглоно.</p>
10.	Экваторын Гвиней	<p>9.2.Экваторын Гвинейн Улсын улс төрийн намуудын нэр нь 1968 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө оршин байсан намын нэртэй ижил байж болохгүй бөгөөд овог аймаг, угсаатан, бүс нутаг, тойрог, хот, хүйс, шашин шүтлэг, нийгмийн байдал, мэргэжил, эсхүл эрхэлж байгаа ажилд үндэслэх ёсгүй бөгөөд улс төрийн намуудын үйл ажиллагаа нь үндэсний эрх ашигт нийцсэн байх.</p> <p>Улс төрийн нам байгуулах, түүний үйл ажиллагааг хуулиар зохицуулна.</p>

Хоёр. УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТ

Улс төрийн намын санхүүжилтийг зохистой шийдвэрлэх нь улс төрийн төдийгүй эдийн засгийн хувьд ихээхэн ач холбогдолтой. Өнөө үед эдийн засгийн хямралыг арилгах, нам дахь авлигын сүлжээг саармагжуулах үйл явц намуудын санхүүжилтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэснээс ихээхэн хамаарч байна.

Намын санхүүжилтийг аливаа улс төрийн намын оршихуйн суурь нөхцөл гэж үздэг. Нам санхүүжилтийн асуудлаа зүй зохистой шийдвэрлэсэн байдлаас хамаарч улс орны улс төрийн амьдрал, тогтолцоо, улмаар эдийн засгийн өнөөгийн төлөв байдал тогтворжин зүгшрэх учиртай. Намын санхүүжилтийг үр нөлөөтэй, зохистой шийдвэрлэх ямар хувилбар, боломж, механизм, гарц шийдэл байгаа талаар улс төрчид, судлаачид санал бодлоо идэвхтэй солилцсоор байна. Ардчиллын төлөөх үндэсний сан (NED)-аас эрхлэн намын санхүүжилттэй холбоотой судалгааг хэвлүүлсэн байна.⁶

Улс төрийн намууд бол төлөөллийн ардчилалд онцгой үүрэгтэй оролцогч институт мөн. Энэ агуулгаараа үзэл суртлын болон төрийн бодлого зохицуулалтын үйл хэрэгт чухал нөлөөтэй, мөн улс төр дэх шударга өрсөлдөөнийг дэмжихэд намуудын үүрэг их юм. Намууд гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх, мөн гүйцэтгэгчийн үүргийг өөртөө хүлээдэг. Өөрөөр хэлбэл, засгийн газрын шийдвэр, бодлого боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог хангах үр нөлөөтэй суваг, чухал механизм нь улс төрийн намууд байдаг.

Улс төрийн намууд өөрт хамаарах үүргээ ардчилсан, үр өгөөжтэй байдлаар бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн болон бусад бодит эх үүсвэр, эдийн засгийн хувьд хүчтэй байж, түүний дэмжлэгт түшиглэх нь тэдний оршин тогтнох хийгээд улс төрийн намын байнгын, тасралтгүй үйл ажиллагааг хангах суурь нөхцөл болдог. Ингэхдээ тухайн хуримтлуулсан нөөц боломжийг өөрийн улс төрийн институцийн суурь бүтцийг бэхжүүлэх, иргэдтэй харилцах, тэдний улс төрийн оролцоог дээшлүүлэх, нийгмийг нийгэмшүүлэх үйл хэрэгт зохистой ашиглах, түүний хүртээмж нөлөөг өргөн түвшинд түгээн дэлгэрүүлэх нь намуудын эн тэргүүнд анхаарах зүйл мөн.

Ихэнх ардчилсан орнуудад улс төрийн намууд өөрсдийн санхүүжилтийг хувийн болон төрийн эх үүсвэрээс авч үйл ажиллагаагаа явуулдаг. Ингэхдээ дараахь хоёр зүйлийн харьцаа тэнцвэрийг хангах тал дээр анхаардаг байна. **Израил**ийн улс төрийн намуудын санхүүжилтийн дийлэнх хувь (85 орчим хувь)-ийг улсаас дэмжлэг авах байдлаар санхүүждэг бол **АНУ**-ын улс төрийн намууд их төлөв хувийн секторын эх үүсвэрээс санхүүждэг байна. Гэтэл **АНУ**-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын зардал, үйл ажиллагааны эх үүсвэр нь шууд төрийн сангаар дамжин суурь санхүүжилтээ авдаг онцлогтой. Энэ нь намууд төрийн болон хувийн хэвшлийн эх үүсвэрийн санхүүжилтийн харилцан

⁶ National Democratic Institute for International Affairs (NDI). The Public Funding of Political Parties: An International Comparative Study. National Endowment for Democracy (NED). Jet line Visual Communications, Johannesburg, South Africa. 1999. Эх сурвалж: **Улс төрийн намуудын санхүүжилт: харьцуулсан судалгааны тойм**. Орчуулсан О.Хатанболд (Ph.D). Философи, эрхийн асуудал. XXXI боть. ШУА-ийн Философийн хүрээлэн. УБ., 2016. 354-362 дахь тал.

хамаарал, тэнцвэрийг аль болохоор хангахад анхаардаг гэдгийг харуулж байна. Намын санхүүжилтийн дээрх хоёр хувилбар нь улс төрийн орчны хамаарал, нөлөө үр дүнг шаардахын хамт түүнд зохион байгуулалтын болон захиргааны нэмэлт тодорхой арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэхийг шаарддаг.

Зарим тохиолдолд төрийн болон хувийн эх үүсвэрээс зэрэгцэн санхүүжих хэлбэр нь маргаан дагуулдаг хэдий ч түүнийг Үндсэн хуулиар баталгаажуулан зөвшөөрдөг тул бэрхшээл төдийлөн үүсдэггүй байна. АНУ-д улс төрийн намууд дахь хувиараа хандивлагчид нь тус орны Үндсэн хуулиар хамгаалагдаж байдаг төдийгүй тэдэнд олгогдсон үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх суурь эрх чөлөө нь нээлттэй хэрэгждэг.

Бусад улс орнуудад тухайн улс төрийн намуудад хандив өгөх хувиараа хандивлагчдын хандивын хэмжээг хуулиар тодорхой хязгаарласан байдаг. Энэ нь улс төр дэх иргэдийн тэгш байдлыг хангах, баян ядуугийн ялгааг багасгах, хувь хүний авьяас чадварыг хөгжүүлэхэд тустай байдаг аж. Зарим улс орнуудын Үндсэн хуулинд улс төрийн намуудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор тэдэнд тодорхой санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг хүлээн зөвшөөрдөг. Тухайлбал, **Франц, Герман, Малави, Мексик, Намиби, Португал** зэрэг улс орнуудад улс төрийн намуудыг төрөөс санхүүжүүлдэг байна.

Харин **Өмнөд Африкийн** Үндсэн хуулинд улс төрийн намуудын нийгэмд гүйцэтгэх үүргийг улс орон дахь олон үндэстэн ястнуудын хүрээнд бий болсон ашиг сонирхлуудыг жигд анхааран харгалзаж, тэдний төлөө ажиллах явдал гэж үздэг.

ӨМНӨД АФРИКИЙН БҮГД НАЙРАМДАХ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАС (1996)

55-р зүйл. Үндэсний Ассамблейн бүрэн эрх

2. Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хууль тогтоомжид дор дурдсан асуудлыг тусгана:

- б) Үндэсний Ассамблейд төлөөлж буй цөөнхийн намууд Үндэсний Ассамблей, түүний Хороодын үйл ажиллагаанд ардчиллын зарчмын дагуу оролцох;
- в) улс төрийн намууд, тэдгээрийн удирдлагууд Үндэсний Ассамблейд чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх боломжийг бүрдүүлэхийн тулд Үндэсний Ассамблейд суудалтай бүх улс төрийн **намд тэдгээрийн төлөөлөлтэй тэнцүү санхүүгийн болон улс төрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;**

236-р зүйл. Улс төрийн намуудын санхүүжилт

Олон намын ардчиллыг, үндэсний хэмжээний хууль тогтоомжийг сахин биелүүлэх зорилгоор улс төрийн намыг санхүүжүүлж, тэдний үндэсний болон бус нутгийн түвшин дэх хууль тогтоох үйл ажиллагаанд эрх тэгш, тэнцүү байдлыг ханган ажиллахыг чухалчилна.

Эндээс үзэхэд, улс орнууд улс төрийн намыг санхүүжүүлэхдээ тухайн нам нь хууль эрх зүйн хүрээнд тогтвортой ажиллах, ардчиллын суурь зарчимд үндэслэсэн улс төрийн намуудын шударга өрсөлдөөн, улс төрийн оролцооны зохистой орчинг хэрхэн бодиттой хангаж буйг нь үндэслэн тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг болохыг харуулж байна. Үүний тулд хууль эрх зүйн хүрээнд дараахь асуудлуудыг нухацтай авч үзэхийг чухалчлах хэрэгтэй болдог. Үүнд:

1) намын санхүүжилтийн тогтолцооны гол үндэс юу болох; төрөөс санхүүжих нь тухайн улс төрийн намд санхүүжилтийн үндсэн эх үүсвэр болж чадаж буйг тодруулсан байх; хувиараа хандивлагчид санхүүжилтийн нийт хэдэн хувийг бүрдүүлдэг эсэх, хувийн болон төрийн санхүүжилтийн зохистой харьцаа тэнцвэрийг хэрхэн, яаж хангах; төрийн санхүүжилтийн эх үүсвэрийг ямар болзлоор хэрхэн түгээх; төрийн санхүүжилтийн зарцуулалтыг хэрхэн тайлагнах;

2) улс төрийн намуудын санхүүжилтийн зарцуулалтад ямар зохицуулалт, механизм, арга хэмжээг авч хэрэгжүүлж буй; санхүүгийн нөөц чадавхын зарцуулалтын хэмжээг тогтоох боломжтой эсэх; зарцуулалтын эргэн тайлагнах хэлбэр түүний хэрэгжилт ямар болох;

3) улс төрийн намуудад хувиараа хандивлагчдын зүгээс үзүүлж буй санхүүгийн дэмжлэгт ямар зохицуулалт хийгдэх; хувиараа хандивлагчид намд санхүүгийн хандив өгөхөд нь ямар нэгэн хязгаар байдаг эсэх; Хувиараа хандивлагчдаас авсан санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтын талаар тодруулга, тайлагнах ямар арга хэмжээ авдаг эсэх;

4) хууль сахиулах байгууллагуудын зүгээс улс төрийн намын санхүүжилтийн тогтолцоо, түүний хэрэгжилтийн үйл явцад шударга зарчмын хэрэгжилт, эргэж хянах хэлбэр, түүний бодитой үр өгөөжтэй, үнэн зөв эсэх; тухайн хяналтын байгууллага нь засгийн газрын болон бие даасан хараат бус байгууллагын аль нь байх эсэх, түүнийг нь хэн удирдах, тэдний эрх мэдлийн байдал ямар байх;

5) хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн харилцах улс төрийн намууд чөлөөт, шударга хэвлэл мэдээллээс татаас, дэмжлэг авдаг эсэх; хэвлэл мэдээллийн байгууллагууд улс төрийн намуудаас чөлөөт болон тодорхой хэлбэрээр татаас авдаг эсэх.

Дээрх шаардлагуудыг шийдвэрлэснээр улс төрийн намуудын санхүүжилтийн хэлбэр механизмын тухай дараахь чиг баримжаа гарч байна. Үүнд:

- 1.төрөөс санхүүжих;
- 2.хувийн хандивлагчдаас санхүүжих;
- 3.төр болон хувийн санхүүжилтийн хосолсон хувилбараар санхүүжих;
- 4.хувиараа хандивлагчдад зарцуулалтын талаар нээлттэй тайлагнах;
- 5.зарцуулах журам;
- 6.зарцуулалтын нээлттэй тайлан;
- 7.хууль сахиулах, албан шаардлага;
- 8.хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх.

Ихэнх ардчилсан улс орнуудад улс төрийн намууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс улс төрийн намуудын зүгээс олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ хууль эрх зүйн хүрээнд чанд нарийн гүйцэтгэж, улмаар санхүүгийн дэмжлэгээ зохих журмын дагуу тайлагнаж, олон нийтийн өмнө хариуцлага хүлээх чадвартай байхыг шаарддаг. Энэ нь тухайн улс орнуудад хариуцлагатай, шударга, ил тод, нээлттэй үйл ажиллагааг явуулах ардчилсан улс төрийн намуудын үйл ажиллагааны хамгийн чухал үүрэг, үнэт зүйлс болж байна.

2.1.Төрөөс санхүүжих

Олон улсын түвшинд хийгдсэн харьцуулсан туршлагаас үзэхэд, улс төрийн намуудын төрөөс санхүүжих хэлбэр нь янз бүрийн зорилготой хэрэгждэг. Төрийн санхүүжилтийн тогтолцоо нь сонгуулийн үйл ажиллагааг дэмжихийг илүүд үздэг байх, эсхүл улс төрийн намуудад сонгуулийн үйл явцад зардлаа хэтрүүлснээс үүдсэн санхүүгийн алдагдлаа нөхөх зорилгоор тэдэнд бага хэмжээний грант төслөөр дэмжлэг үзүүлэх хэлбэр байна.

Улс төрийн намуудыг төрөөс санхүүжүүлэх хоёр дахь чухал хэлбэр нь парламентын сонгуулиар дамжуулан улс төрд оролцогчдод дэмжлэг үзүүлэх хэлбэр юм. Үүнийгээ улс төрийн намын “дотоод үйл ажиллагааны зардал” гэж тайлбарладаг. Үнэндээ, төрийн санхүүжилтийн тогтолцоо нь тухайн улс төрийн намуудын төлөөллийн үндсэн зарчим, тэгш байдлыг тэнцвэржүүлэх зорилготой хуваарилалтын хэлбэр болдог.

2.2.Хувийн хандивлагчдаас санхүүжих

Хувийн хандивлагчдаас санхүүжих нь ихэнх улс орнуудад амжилттай хэрэгжиж буй санхүүжилтийн нэг хувилбар юм. Хувийн хандивлагчдаас санхүүгийн дэмжлэг авч, улс төрийн үйл ажиллагаагаа явуулах нь санхүүжилтийн түгээмэл хэлбэр болдог. Улс төрийн намуудын хувьд намын гишүүдээс санхүүгийн дэмжлэг авахын зэрэгцээ нам бус бусад дэмжигчдийн зүгээс санхүүгийн хандив цуглуулах явдал нэлээд өргөн хүрээг хамардаг. Намын санхүүжилтийн хүрээн дэх хувийн хандивлагчид болон улс төрийн намуудын хоорондын итгэлцлийн гол түлхүүр нь харилцан тайлан гаргах явдал юм.

Германд⁷ улс төрийн намыг төрөөс санхүүжүүлэхдээ тодорхой хувь тогтоох бөгөөд тухайн улс төрийн намд хуулийн хүрээнд тодорхой нөхцөлтэйгөөр санхүүжилтийг олгодог. Энэ нь тухайн улс төрийн намуудыг хувийн хандивлагчдаас авсан санхүүгийн дэмжлэгийн өмнө хариуцлага хүлээж, тайлагнахыг баталгаажуулдгаар онцлогтой. Хувийн хандивлагчдад итгэл үзүүлэхдээ тухайн хандивлагчдын хандив өгөх эрх зүйн болон бусад талын боломжийг хангах тал дээр анхаардаг байна. Тэгэхдээ хандивлагчийн намын болон улс төрийн тогтолцоо, үйл явцад шууд хөндлөнгөөс оролцох явдлыг сааруулах тал дээр ч мөн давхар анхаардаг байна.

⁷ Act on Political Parties of 24 July 1967. Эх сурвалж: <https://www.bundestag.de/blob/189734/2f4532b00e4071444a62f360416cac77/politicalparties-data.pdf>

ХБНГУ-ЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛИАС (1967)

18 дугаар зүйл. Төрөөс үзүүлэх санхүүжилтийн зарчим, хүрээ

(1) Үндсэн хуульд заасны дагуу намуудын үйл ажиллагааг хэсэгчлэн санхүүжүүлнэ. Төрийн сангаас санхүүжилт хуваарилах шалгуур нь намуудын Европын холбоо, Бундестаг, Орон нутгийн парламентын сонгуульд санал авсан хувь болон түүний гишүүдийн татвар, төрийн байгууллагуудад сонгогдсон албан тушаалтнуудын болон хүлээн авсан бусад хандивын нийт дүнтэй тэнцүү байна.

(2) Төрийн сангаас улс төрийн намуудад жил бүр хуваарилж болох санхүүжилтийн дээд хэмжээ 133 сая евро (дээд хязгаар) байна.

(3) Улс төрийн намууд төсвөөс хэсэгчилсэн санхүүжилтийн хүрээнд жилд дараахь нийт дүнг авна:

1. намуудын нэрсийн жагсаалтад хүчин төгөлдөр санал тус бүрт 0,70 евро;
2. хэрэв намын нэрсийн жагсаалтыг Орон нутгийн түвшинд хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн намд өгсөн санал тус бүрт 0,70 евро;
3. бусад эх сурвалжаас авсан евро тус бүрт 0.38 евро (гишүүнчлэлийн татвар, хандив, албан тушаалд сонгогдсон албан тушаалтнуудын өгсөн, эсхүл хуулийн дагуу авсан хандив); хандивыг зөвхөн нэг хүнд ногдох хэмжээ нь 3,300 хүртэл еврог тооцно.

Энэ хэсгийн 1, 2-т заасан хэмжээг өөрчлөхийн тулд намд өгсөн 4 сая хүртэлх хүчин төгөлдөр саналд 0.85 евро авна.

19а дугаар зүйл. Санхүүжилтийн түвшинг тодорхойлох журам

(1) Германы Бундестагийн Ерөнхийлөгч улс төрийн намд хуваарилагдах өнгөрсөн жилийн төрийн сангийн санхүүжилтийн хэмжээг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор тодорхойлно...

24 дүгээр зүйл. Орлого, зарлага

(4) Орлого нь:

1. гишүүдийн татвар;
2. сонгуульд албан тушаалтнуудын өгсөн хандив, түүнтэй төстэй тогтмол шимтгэл;
3. хувь хүмүүсээс өгсөн хандив;
4. хуулийн этгээдээс өгсөн хандив;
5. үйл ажиллагаанаас олсон орлого;
6. хөрөнгийн орлого;
7. хэвлэмэл материалаас олсон;
8. төрийн сан;
9. бусад орлого;
10. намын салбар байгууллагаас авсан буцалтгүй тусламж;
11. энэ зүйлийн 1-10-д заасан нийт орлого зэргээс бүрдэнэ.

(5) Зарлага нь:

1. боловсон хүчний холбоотой зардал;
2. үйл ажиллагааны зардал:
 - а) өдөр тутмын үйл ажиллагаа;
 - б) намын үндсэн ажил;
 - в) сонгуулийн кампанит ажил;
 - г) активын удирдлага, түүний хүү;
 - д) бусад сонирхол;
 - е) бусад зардлууд;
4. намын салбар байгууллагуудад олгосон буцалтгүй тусламж;
6. энэ зүйлийн 1-3-д заасан нийт зардал зэргээс бүрдэнэ.

25 дугаар зүйл. Хандив

(1) Улс төрийн намууд хандив хүлээн авах эрхтэй. Хандивыг 1,000 хүртэл еврогийн бэлэн мөнгөөр хийж болно. Улс төрийн намын нэрийн өмнөөс хандив хүлээн авсан намын гишүүд нь хандивыг нэн даруй намын санхүүгийн асуудалд хариуцсан Гүйцэтгэх хорооны гишүүнд шилжүүлнэ. Намын санхүүгийн асуудал хариуцсан Гүйцэтгэх хорооны гишүүн, эсхүл тухайн намын орон тооны ажилтан-гишүүн нь хандивыг захиран зарцуулах эрх олж авсан үед хандив авсан гэж үзнэ. Хандивлагч этгээдэд хандивыг нэн даруй буцаан өгсөн бол улс төрийн нам хандив хүлээн авсанд тооцохгүй.

2.3. Төр болон хувийн хосолсон хувилбараар санхүүжих

Улс төрийн намуудын хувийн хандивлагчдаас санхүүжих явдлыг хязгаарлахын тулд дараахь хоёр хүчин зүйлсийг авч үзэх хэрэгтэй. Үүнд:

- 1) зөвшөөрөгдсөн тодорхой хэмжээний хандивыг хүлээж авах;
- 2) тогтсон эх үүсвэрээс санхүүжих, тухайлбал, **Израиль** болон **АНУ**-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн төрийн болон хувийн хандивлагчдын зүгээс санхүүжих хосолсон механизмтай.

Энэтхэгийн хувьд, хувиараа аль нэг улс төрийн намд хандив өгөх тохиолдолд тухайн хандивын хэмжээний хязгаарыг тогтоосон байдаг төдийгүй тухайн хандивлагчид ямар нэгэн албан тушаал олгох, амлалт өгөх явдлыг шууд хориглодог байна. **Өмнөд Африкт** улс төрийн намуудад шууд хандив өгөх асуудалд төдийлөн анхаарал хандуулдаггүй, харин тусгай санд хандивыг татан төвлөрүүлэхийг зорьдог байна. Мөн **Өмнөд Африкт** улс төрийн намуудыг санхүүжүүлэхдээ юуны өмнө тухайн намыг парламентад болон орон нутгийн хууль тогтоох байгууллагад оролцож буй төлөөллийг харгалзах байдлаар улс төрийн намуудын төлөөллийг нэн тэргүүнд авч үзэх байдлаар санг бүрдүүлдэг ажээ.

Түүнчлэн зарим хуульд хувийн хандивлагчдын эх үүсвэрт тодорхой хязгаарлалт хийдэг. Үүнийг тодорхой хоёр энгийн шалтгааны улмаас хязгаарладаг байна. Энэ нь тухайн улс төрийн намуудын санхүүжилтэд гадаадын болон нэр үл мэдэгдэх хувь хүн, байгууллагаас санхүүжихийг хатуу хориглодог. Харьцуулсан судалгаанд хамрагдсан **Австрали, Канад, Герман, Энэтхэг, Израиль, Швед, Шинэ Зеланд, Өмнөд Солонгос, Зимбабве, АНУ, Өмнөд Африк** зэрэг улс орнуудад нэр үл мэдэгдэх хандивлагчдаас ирүүлсэн хандиваар улс төрийн намууд санхүүжихийг хатуу хориглодог байна.

АНУ, Канад, Энэтхэг, Израиль зэрэг улсуудын хувьд гадаадын хандивлагчдаас ямар нэгэн санхүүгийн дэмжлэг, хандив цуглуулах, авахыг шууд хориглодгийн зэрэгцээ **Герман, Израиль, АНУ**-ын хувьд томоохон үндэстэн дамнасан, эсхүл том хэмжээний корпорацуудаас улс төрийн намуудад хандив өгөх, санхүүгийн дэмжлэг авахыг мөн хатуу хориглосон байдаг.

2.4.Хувиараа хандивлагчдад зарцуулалтын талаар нээлттэй тайлагнах

Ихэнх улс төрийн намуудын санхүүжилтийн тогтолцоонд нийтлэг хадгалагддаг шинж бол хувиараа хандивлагчдад тэдний санхүүжилтийн талаар нээлттэй тайлан хийхийг нэн тэргүүнд шаардаж, онцгой анхаарал хандуулдаг явдал юм. Харин эл судалгаанд хамрагдсан улс орнуудаас **Өмнөд Африк, Швед, Зимбабве** зэрэг улсад хувь хандивлагчдаас ирүүлсэн хандивын зарцуулалтад ямар нэгэн санхүүгийн нээлттэй тайлан, танилцуулга хийдэггүй. Гэсэн хэдий ч ихэнх орнуудад улс төрийн намуудад өгөх хандивын босгыг тогтоосон байдаг бөгөөд үүний гол зорилго нь тодорхой хэмжээнээс дээш хандив өгөхийг зөвшөөрсөнтэй холбоотойгоор зарцуулалтын талаарх санхүүгийн нээлттэй тайлан хийх механизмыг давхар бий болгосон явдал юм. Санхүүжилтийн босгын хувьд улс орон бүр янз бүрийн хэмжээ тогтоосон байдаг. **Канад** тухайн улс төрийн намуудад 80 ам.доллараас дээш хандив өгсөн бүх хүмүүс, дэмжигчдэд санхүүгийн нээлттэй тайланг гаргаж өгөх үүрэгтэй, **Германд** сонгуулийн хандивын босгыг ойролцоогоор 11.000 ам.доллараар тогтоосон бол, **Израильд** хандив өгсөн бүх хүмүүст хандивын зарцуулалтын тайланг танилцуулах, тэд тайлан өгөх үүрэгтэй ч хандивын тогтсон босго гэж байдаггүй.

Өөрөөр хэлбэл, улс төрийн намуудын захиргааны аппаратын зүгээс санхүүгийн нээлттэй тайланг олон улсын жишиг загварыг үндэслэн тайлагнадаг. Тухайн хандивын тайланг хандивлагчдын нэрсийн жагсаалт, хаягийн бүртгэлийн дагуу жагсаан тайлагнах бөгөөд ихэнхи улс оронд санхүүгийн нээлттэй тайлан-тэнцэлийг жил бүрээр гаргаж тайлагнадаг байна.

2.5.Зарцуулах журам

Улс төрийн намын санхүүжилтийн зарцуулалтыг тайлагнах журам нь ерөнхийдөө тухайн хандивын хэмжээ, зарцуулалтын хэлбэр гэсэн тодорхой хүчин зүйлсээс хамаардаг байна. Улс төрийн намын хандивын зарцуулалтыг зөвшөөрөгдсөн хэмжээгээр хязгаар тогтоох нь түгээмэл байдаг.

Судалгаанд хамрагдсан улс орнуудад энэхүү томъёоллын дагуу өөрсдийн хандивын зарцуулалтын хэмжээ, хязгаарыг тогтоосон найман улс байхад, **Австрали, Герман, Швед** зэрэг орнуудын хувьд улс төрийн намуудын хандивын зарцуулалтын хэмжээний талаар ямар нэгэн хязгаар тогтоогоогүй байна. Харин **Өмнөд Солонгос, Шинэ Зеланд** зэрэг орнууд улс төрийн намын сонгуулийн үйл ажиллагаанд зориулан хандивласан хандив, мөнгөний зарцуулалтыг хараат бус бүлгүүдийн дэмжлэгтэйгээр хязгаартайгаар зарцуулж түүнийгээ тайлагнана. Улс төрийн намуудын хандивын зөвшөөрөгдсөн хэмжээний хандивын зарцуулалтын хэлбэр, мөнгөн дүнгийн хязгаарыг хуулийн зүйл, заалтаар тодорхойлон гаргасан байдаг. Ингэхдээ улс орнуудад улс төрийн намын санхүүжилтийг хувийн зорилгоор ашиглах, зарцуулахыг хатуу хориглодог ч тодорхой хэмжээний зөвшөөрөгдсөн зарцуулалтыг тодорхой тайлагнахыг чухалчилдаг. **Германы** хуулинд зөвшөөрөгдсөн зардлыг дараахь долоон хэсэгт ангилан хувааж тус бүрээр нь тодорхойлсон байдаг. Тухайлбал, намын албан хаагчид, одоогийн бизнесийн үйл ажиллагаа, намын ерөнхий үйл ажиллагаа, сонгууль, ашиг орлого,

бусад зарцуулалт, төсвийн хуваарилалт болон хэсэгчилсэн хуваарилалт, зарцуулалтыг багтаасан байна.

2.6.Зарцуулалтын нээлттэй тайлан

Улс төрийн намын санхүүжилтийн зарцуулалтын тайланг бараг бүх тогтолцоонд нийтлэг байдаг. Эл судалгаанд хамрагдсан улс орнууд болон **Швед**ээс бусад орнуудад зарцуулалтын тайланг төдийлөн чухалчилдаггүй. Мэдээж хэрэг, ихэнх орнуудад санхүүжилтийн зарцуулалтыг тайланг шаардах боловч **Австрали, Канад** зэрэг улсад зарцуулалтын босгыг нарийн сайн тогтоосон байх боловч түүнийг заавал тайлагнахыг шаарддаггүй байна. Улс орнууд тайлагнахдаа өөр хоорондоо ялгаатайгаар тайлагнана.

Намын санхүүжилтийн зарцуулалтын тайлангийн чухал асуудал бол тухайн намын санхүүгийн үйл ажиллагаа, зарцуулалтын талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх, тэдний саналыг тусгах явдал мөн. Энэ талаар хийгдсэн туршлага нь өөр хоорондоо ялгаатай. **Австрали, Герман, Энэтхэг, Израиль, Шинэ Зеланд, АНУ** зэрэг орнууд зарцуулалтын санхүүгийн нээлттэй тайланг нийтэд түгээж болдог. Харин **Канадын** хувьд олон нийтийн өмнө танилцуулахын зэрэгцээ бие даасан хөндлөнгийн байгууллагуудаар хянуулж, хөндлөнгийн тайлан бичүүлэх зэрэг хосолмол аргыг хэрэглэдэг байна. **Солонгосын** тухайд санхүүгийн зарцуулалтыг намын удирдах албан тушаалтнууд, сонгуулийн төв байгууллагын албан хаагчид, нэр дэвшигчид болон намын ажилтнуудад танилцуулах тогтолцоотой. Харин **Өмнөд Африк, Зимбабве** зэрэг орнуудад санхүүгийн нээлттэй тайлан танилцуулах орчин байдаг хэдий ч түүнийг яг нарийвчлан дагаж мөрддөг талаарх тодорхой мэдээлэл, кейс байдаггүй.

2.7.Хууль сахиулах, албан шаардлага

Хууль сахиулах байгууллагуудын хувьд улс төрийн намын санхүүжилтийн тогтолцооны үйл ажиллагааны болон хэрэгжилтийн байдлыг хөндлөнгөөс шүүмжлэлт байр сууринаас нарийвчлан хянахад анхаардаг. Энэхүү үйл ажиллагааны эрх, үүргийг хууль сахиулах байгууллагуудад шууд олгосон нь ихээхэн чухал зүйл. **Канад, АНУ, Шинэ Зеланд, Өмнөд Африк** зэрэг орнуудад энэ чиглэлээр бие даасан хараат бус байгууллагыг засаг захиргааны дунд шатны байгууллагуудын төлөөллийг оролцуулсан байдлаар төрийн байгууллагын статустайгаар байгуулсан байдаг. Дурдсан улс орнуудад хараат бус сонгуулийн хорооны дэргэд төрийн сангаас хуваарилагдсан санхүүжилтийн зарцуулалт, намуудын төсвийн хуваарилалт зэргийг хянах, хөндлөнгийн дүгнэлт өгөх хууль шүүхийн эрх бүхий эрх зүйн этгээдийг томилон маргааныг тасалж, шийдвэрлэх эрхийг олгодог. **Израильд** энэхүү эрх бүхий этгээдийг хууль сахиулах байгууллагаас томилж Төрийн хянагч (State Comptroller) гэж нэрлэдэг.

Германд энэ тохиолдолд Бундестагийн (Парламентын доод танхимын) дарга энэ албыг хашдаг. Хуульд заасны дагуу Бундестагийн дарга тухайн улс төрийн нам төрийн санхүүжилтийг хэрхэн зарцуулсан болон сонгогдсон улс төрийн нам үүнийг хэрхэн хуваарилсан эсэхийг хянан шалгаж, хэрэв ямар нэгэн алдаа дутагдал гарсан бол тухайн намд торгууль, шийтгэл ногдуулах эрх

мэдэлтэй байдаг байна. Сонгуулийн хороо нь улс төрийн намуудын санхүүжилтийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, мөрдөн шалгалт хийх, прокурорын дүгнэлт гаргуулж, хэрвээ шаардлагатай тохиолдолд холбогдох хэрэг үүсгэж, шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэх бүрэн эрхтэй.

2.8.Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх

Ихэнх улс төрийн намуудын хувьд хэвлэл мэдээллийн байгууллагуудад зарцуулах хөрөнгө зардал ихээхэн чухал байр эзэлдэг. Тухайлбал, Сонгуулийн компанийн үеэр хэвлэл мэдээлэлд намын нийт санхүүжилтийн 40-70 орчим хувийг зарцуулдаг бөгөөд энэ нь улс төрийн намуудын санхүүжилтийн тогтолцоонд тодорхой жин дарж, намуудын мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагаагаа сурталчлах, үйл хэрэгт нь зарцуулагддаг байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх мэдээллийн цаг нь хоёр үндсэн аргаар хангагдана.Энэ нь засгийн газраас тодорхой тогтсон хэвлэл мэдээллийн байгууллагуудыг санхүүжүүлэх, эсхүл засгийн газрын зүгээс өөрийн зөвшөөрөлтэй мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэнцвэртэй мэдээллийг олон нийтэд давтамжтай байдлаар цацах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Түүнчлэн хувийн болон төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл дамжуулах боломж орчинг тэнцвэртэй бүрдүүлэхийг чухалчилдаг. Ихэнх оронд олон нийтийн телевиз, радио байдаг бөгөөд тэдгээр нь парламентын болон сонгуулийн улс төрийн үйл ажиллагаанд оролцоход нь улс төрийн намуудад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Германд энэ үүргийг хэрхэн ханган биелүүлж буйг тус улсын Үндсэн хуулийн шүүхээс өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу олон нийтийн болон хувийн салбарын хэвлэл мэдээллийн хэрэгслээр тэнцвэртэй дамжуулахыг шаарддаг. Гэхдээ улс төрийн намуудын зүгээс энэ чиглэлээр нарийн тогтсон стандарт, мөрдөх журам төдийлөн байхгүй ч, **АНУ** зэрэг зарим улсад төрийн болон хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр улс төрийн намууд өөрсдийн үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд түгээхэд арилжааны хамгийн доод үнийг санал болгодог.

Канадад чөлөөт, хувийн салбарын хэвлэл мэдээллийн хэрэгслээр өөрийн үйл ажиллагааг сурталчлах мэдээллийн цагийг дамжуулах нарийн тогтсон нөхцөл байдал байдаггүй ч тухайн мэдээллийг дамжуулахдаа аль нэг талыг баримталсан байдлаас аль болох зайлсхийх, тэнцвэртэй байр суурийг ханган ажиллахыг шаарддаг. Зарим орнуудад улс төрийн намуудад мэдээллийн цагийг олгохдоо тодорхой хязгаартайгаар олгодог. Түүнчлэн **Энэтхэг, Израиль** зэрэг улсад улс төрийн намууд сонгуулийн компанийн үеэр төлбөртэй сурталчилгаа, нэвтрүүлэг явуулахыг хатуу хориглодог. **Австрали, Канад, Шинэ Зеланд, Швед, АНУ**-д зар сурталчилгаанд төлбөр төлөхийг зөвшөөрдөг. Канадад сонгууль болохоос өмнөх 48 цагийн дотор сурталчилгаа явуулахыг хориглоно.

Солонгост улс төрийн намуудад төлбөртэй нэвтрүүлэг, сурталчилгаа явуулахыг зөвшөөрдөггүй ч харин нэр дэвшигчдэд зөвшөөрдөг. Хэрэв тухайн улс төрийн намууд, нэр дэвшигчдийн зүгээс өөрсдийн үйл ажиллагааны талаар бэлтгэсэн нэвтрүүлгийг өөрсдөө хийсэн бол түүнийг олон нийтэд түгээх, өргөн

нэвтрүүлгээр цацах тохиолдолд эхлээд хэвлэл мэдээллийн хэрэгслийн байгууллагуудаас тухайн нэвтрүүлгийг хянан үзэж, тодорхой шалгуураар хяналт тавьсны дараа уг мэдээллийг олон нийтэд цацдаг байна. **Австрали, Канад, Солонгос, Шинэ Зеланд, АНУ** зэрэг улс орнууд үүнтэй нэгэн адил тодорхой дагаж мөрдөх зохицуулалттай.